

**БАТЛАВ:**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА Г.ЧИНЗОРИГ**

  
/гарын үсэг/



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын Газар**

**“РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ ХЯНАЛТ МОНИТОРИНГ  
ХИЙХ” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

**ТЕНДЕРИЙН ДУГААР: ХХЗХ/202401038**

**БАГЦЫН ДУГААР: Багц 3 АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, "РАДИО,  
ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ,  
РАДИО, ТЕЛЕВИЗИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ ЖУРАМ"-ЫН  
ХҮРЭЭНД РАДИОГООР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД  
ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ**

2024 он



## АГУУЛГА

1. Үндэслэл
2. Зорилго
3. Хяналт, мониторингийн хамрах хүрээ
4. Хяналт, мониторинг хийх үзүүлэлт
5. Хяналт, мониторинг хийхэд баримтлах зарчим
6. Тайлан
7. Ажлын даалгаврын шалгуур шаардлага
8. Хэрэгжүүлэх арга зүй ба ажлын хуваарь
9. Тайлан ирүүлэх удирдамж
10. Мониторингийн тайлангийн бүтэц /загвар/
11. Хавсралт 1 радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт

## 1. ҮНДЭСЛЭЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45, 47 дугаар зүйлд заасан чиг үүргийн дагуу радио өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хяналт тавих шаардлага гарч байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр радиогоор нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд энэ хууль болон Сонгуулийн ерөнхий хорооноос батлан гаргах “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-д заасны дагуу хяналт, мониторинг хийж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах юм.

## 2. ЗОРИЛГО

Энэхүү ажлын даалгаврын гол зорилго нь нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйл, тус хуульд заасан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-д заасан үзүүлэлтүүдээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий нийт УБ хотын 32 радиогийн эфирийн бичлэгийг хийж, **гомдол маргаан гарсан тохиолдолд** эфирийн бичлэгээс мониторингийн нарийвчилсан тайлан, мэдээг гаргаж ажиллах юм. Харин орон нутгийн 27 радиогийн хувьд ХХЗХ-с бичлэг хийж, хүргүүлэх бөгөөд мөн гомдол гарсан тохиолдолд хуульд заасан үзүүлэлтүүдээр мониторингийн тайлан гаргаж ажиллах юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус радиогийн хувьд сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх, сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй радиогийн хувьд хууль, журамд заасан үзүүлэлт нэг бүрээр гаргасан тайлан мэдээнд үндэслэн зөрчлийг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллахад оршино.

## 3. МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

3.1 Монгол улсын их хурлын сонгуулийн үеэр Улаанбаатар хотын 10 радиогийн сигналыг нэгэн зэрэг хүлээн авч, бичлэг хийнэ. Шаардлагатай тохиолдолд хяналт, мониторинг хийнэ.

3.2 Монгол улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеэр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Улаанбаатар хотын болон орон нутгийн радио өргөн нэвтрүүлгийн

(РӨН) үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт гомдол гарсан тохиолдолд захиалагчийн шаардсан тухай бүр хяналт, мониторинг хийнэ.

- 3.3 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын хугацаанд өөрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс тухайн маргаантай холбоотой радио өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн бичлэг авах, холбогдох мэдээллийг гаргуулж авах эрхтэй байна.
- 3.4 Захиалагч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын даалгаварт заасан хяналтын үзүүлэлтээр гарсан тайланг хамтын ажиллагаатай холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж болно.

#### 4. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хуульд заасан сонгуулийн сурталчилгааны хугацаанд, гомдол гарсан тохиолдолд захиалагчийн шаардсан тухай бүр (Нийт УБ хотын 32 радио, орон нутгийн 27 радиогийн бичлэгээс зөвхөн гомдлоор мониторингийн тайлан мэдээ гаргаж ажиллах) дараах үзүүлэлтийн дагуу хяналт, мониторинг хийнэ. “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам” эцэслэн батлагдсан тохиолдолд хяналт, мониторингийн үзүүлэлтэд өөрчлөлт гарч болзошгүй. Хяналт, мониторингийн үзүүлэлтүүд нь:
- 4.1.2. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн протокол; Протокол нь радиогийн нэр, огноо, сурталчилгааны нэвтрүүлгийн нэр, эхэлсэн цаг, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа (цаг:мин:сек-ээр болон сек-ээр), эх сурвалж, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр зэрэг мэдээллийг агуулсан байна.
- 4.1.3. Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 60 минутаас илүүгүй заалтыг хангасан байдал;
- 4.1.4. Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдож байгаа эсэх, шаардлага хангасан эсэх;
- 4.1.5. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглох заалтын хэрэгжилтийн байдал;

- 4.1.6. Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоосон эсэх, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- 4.1.7. Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт хуулиар тогтоосон 60 минут, 15 минутаас илүүгүй байх хугацааг зөрчсөн эсэх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орсоньг дамжуулсан, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх;
- 4.1.8. Сонгуулийн сурталчилгааны эх сурвалжийг ил тод мэдээлсэн байдал. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.
- 4.1.9. Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлгийн хяналт, оролцогчдын төлөөлөл шаардлага хангасан байдал.
- 4.1.10. Улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан эсэх, хэрэгжилтийн байдал; (зөвхөн холбогдох эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу холбогдох дүн, мэдээг гаргах)
- 4.1.11. Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилтийн байдал;
- 4.1.12. Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.
- 4.1.13. Эрх бүхий байгууллагаас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх олгосоноос бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилт;
- 4.1.14. Радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн үндсэн сувгаар нэвтрүүлсэн эсэх;
- 4.1.15. Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.
- 4.1.16. Олон нийтийн радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийн биелэлтэд мониторинг хийх, хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу дахин болон нэмэлт санал хураалт явуулах тохиолдолд дахин болон нэмэлт санал хураалт

явуулж, сонгуулийн албан ёсны дүн зарлагдаж дуусах хугацаанд сонгуулийн сурталчилгаа дамжуулж байгаа эсэхэд хяналт, мониторинг хийх.

4.1.18. Хууль, журамд заасан бусад үзүүлэлт.

- 4.2. Захиалагчаас шаардсаны дагуу холбогдох эфирийн бичлэг, хөтөлбөрийн баримт, нотолгоог шуурхай гаргаж ирүүлнэ.
- 4.3. Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээ, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх.

## 5. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ЧИГЛЭЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу хяналт, мониторинг хийх үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтран баталсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-д заасан өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, сувгийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг баримтална.

### 5.1 Сонгуулийн сурталчилгааны протокол:

- Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоосон эсэх, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт хуулиар тогтоосон 60 минут, 15 минутаас илүүгүй байх хугацааг зөрчсөн эсэх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орсныг дамжуулсан, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх;
- Сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуустал хугацаанд болон дахин болон нэмэлт санал хураалт дуустал хугацаанд сонгуулийн сурталчилгаа болон сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах эсхүл сонгууль оролцогч нам, эвслийн дарга оролцсон сонгуулийн сурталчилгааны бус аливаа нэвтрүүлэг, түүнчлэн тэдгээрийн таних тэмдэг, нэр, зураг, дүрс бичлэгийг гаргасан нэвтрүүлэг нэвтрүүлсэн дамжуулсан эсэх;

### 5.2 Сонгуулийн сурталчилгааны хугацааг тооцохдоо:

- Сонгуулийн сурталчилгааны эх сурвалжийг ил тод мэдээлсэн сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар

товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна.

- Харин энд заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгээ тодорхой илэрхийлээгүй, эх сурвалжийг дурдаагүй боловч сонгуулийн сурталчилгааны болон сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг гаргасан бол сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж тооцно. Үүнд:
  - нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах, эх сурвалжийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол;
  - эх сурвалжийг тодорхой дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс, нэрийг үзэгч, сонгогчдод сонгуулийн сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар харуулах, дурдах, байршуулах, дууны үгэнд дурдсан бол;
  - сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс бичлэг, яриа нь орсон бол.
- Сонгуулийн талаарх дараах нэвтрүүлэг, сурталчилгаа нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй болно. Үүнд:
  - нам, эвсэл, нэр дэвшигчид болон сонгуулийн үйл явцын тухай радио, телевизийн өөрийн редакцын бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, тойм;
  - сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа;
  - улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг;
  - сонгуулийн хороодын албан ёсны мэдээ.

5.3 Нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 (таван) минутаас хэтрүүлэхгүй байх заалтын хугацааг тооцохдоо:

- Мэдээний хоногт гарах таван минутын хугацааг мэдээний нэвтрүүлэгч тухайн мэдээг танилцуулж эхэлсэн хугацаанаас эхлэн тооцно.
- Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.
- Мэдээллийн хөтөлбөр дундуур дамжуулж буй сонгуулийн сурталчилгааны бус цаг үе үйл явдлын шинжтэй сурвалжлага, мэдээгээр нэр дэвшигчийн эрхэлж байгаа ажил үүрэгтэй холбоотой мэдээ, сурвалжлага гарах, мэдээ, сурвалжлага дундуур тухайн нэр дэвшигч тусгайлан яриа өгсөн бол сэдвээс үл хамаарч зөвхөн нэр дэвшигчийн яриа өгсөн цагийг тухайн нэр дэвшигчид оногдох мэдээний 5 минутад хамааруулж тооцно.



5.4 Эрх бүхий байгууллагаас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх олгосноос бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилт;

- Захиалагчийн зүгээс сонгуулийн сурталчилгаа дамжуулах эрх бүхий телевизийн жагсаалтыг гүйцэтгэгчид гаргаж өгнө.
- Радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний компанийн нэгдэл нь хэд хэдэн радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол тэдгээрийн зөвхөн нэг радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлнэ.
- Хүүхэд, теле-худалдааны төрөлжсөн болон төлбөртэй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.

## 6. ТАЙЛАН

6.1. “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын дагуу хуулиар тогтоосон сонгуулийн сурталчилгааны хугацаанд гомдол гарсан тохиолдолд мониторингийн дүн, тайлан мэдээг ирүүлнэ. Хэрэв гомдол ирж, тайлан ирүүлсэн тохиолдолд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журмын хүрээнд сонгуулийн сурталчилгааны нэгдсэн дүн, мэдээг аналитик тайлангийн хамтаар боловсруулж ирүүлнэ.

Сонгуулийн сурталчилгаатай холбоотой тайлан, датаг Захиалагчийн хүсэлт хүргүүлснээс хойш аль болох богино хугацаанд, хамгийн ихдээ 1 хоногийн дотор гаргаж захиалагчид нийлүүлнэ. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.

6.2. Захиалагчаас тухай бүр хүргүүлсэн бичлэгт тайлан гаргах, шаардлагатай тохиолдолд дүнг нэгтгэн, аналитик тайлангийн хамт боловсруулж ирүүлнэ.

6.3. Тайланд хяналт, мониторинг хийгдсэн хугацааны эфирийн 06:00-01:00 цагийн /хөтөлбөрийн/ дэлгэрэнгүй протокол, дэлгэрэнгүй протоколд тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбар зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна.

6.4. Ажлын даалгаврын 4-р зүйлд заасан хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр нэвтрүүлэг эхэлсэн дууссан үргэлжилсэн хугацааг цаг:мин:сек-р гаргах, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, нэмэлт тайлбар хөтөлбөрт эзлэх хувь хэмжээ, 1 хоног, 7 хоног, сараар нэгтгэн гаргах; *Тайлангийн бүтцийн загварыг хавсралт 1-ээс харах*

6.5. Хяналт, мониторингийн тайланг захиалагчийн шаардсан үзүүлэлт тус бүрээр шаталсан дэлгэрэнгүй, хураангуй тайлан гаргах;

6.6. Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор тухайн радиогийн эфирийн бичлэгээс холбогдох нэвтрүүлгийн тодорхой цагийн бичлэг нийлүүлэх;

## 7. АЖЛЫН ДААЛГАВРЫН ШАЛГУУР, ШААРДЛАГА

### 7.1. Ерөнхий шаардлага

- Гүйцэтгэгч болон хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд хамрагдаж байгаа этгээд нь компанийн тухай хуулийн 6.14-т заасан /нэг/ нэгдлийн оролцогчид биш байна.
- Гүйцэтгэгч нь хорооноос олгодог өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч бус байх, гүйцэтгэх удирдлагын хувьд сүүлийн 3 жил аль нэг радиогийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллаагүй байна.

### 7.2. Техникийн болон туршлага, хүний нөөцийн шалгуур

Энэхүү ажил нь радио өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу шат дараатай арга хэмжээ авах үндэслэл шалтгаан болох бөгөөд шат дараатай арга хэмжээнд зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, тусгай зөвшөөрлийг сунгах эсэх талаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ хамаарах тул хянуур нямбай ажиллаж, үнэн зөв алдаагүй тайлан гаргах, эфирийн дэлгэрэнгүй протокол, тайлан зөрүүгүй байх талаар анхаарч ажиллана. Энэхүү ажлын даалгаврыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гэрээлэгч нь дараах чадвар, мэдлэг, туршлагатай байх шаардлагатай.

Үүнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 10 радиогийн бичлэг хийх, хадгалах боломжтой байна.
- Өмнө нь энэ төрлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт гомдол гарсан тохиолдолд гэрээнд заасан хугацаанд хяналт, мониторинг хийх техникийн болон ажиллах хүчний боломжтой байна. */жагсаалтыг хавсралт 1-ээс харал/*
- Дээрх тооны радиогийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх, эфирийн бүрэн бичлэг хийх, хадгалах бүрэн хүчин чадал бүхий сервер, архивын системтэй байна.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа жагсаалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн сигналыг хүлээн авах техникийн шийдэл, нөөц шийдэл, хүчин чадал, байр талбайн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
- Цахилгааны доголдоос хамааралгүйгээр хяналт, мониторингийн үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай хийх боломжтой байх эфирийг тасралтгүй бичих, хэвийн ажиллагааг хангах нөөц станцтай байна.
- Ажлын даалгаварт өгөгдсөн мэдээ, тайлан, эфирийн бичлэг хадгалах мэдээллийн сантай байна.

- Мэдээллийн сангаас ажлын даалгаварт заасны дагуу, шаардлагатай тохиолдолд холбогдох бусад мэдээ, тайлан, эфирийн бичлэгийг тухайн сар, өдөр, цаг минутаар түргэн шуурхай гаргах техник, технологийн боломжтой байна.
- Хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд эфирийн бичлэгийг 6-аас доошгүй сар хадгалах сервер тоног төхөөрөмжтэй байна.
- Хяналт, мониторингийн үйлчилгээг хийх аргачлал, хяналт, мониторингийн ажлын үе шат, хяналт, мониторингийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, үе шат тус бүр дээр хийгдэх ажлын тодорхойлолт, ажилчдын тоо, ажил үүргийн хуваарь /ажлын байрны тодорхойлолт хавсаргах/ зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг хяналтын үзүүлэлт тус бүрээр гаргасан байна.
- Нөхцөл шаардлагад өөрчлөлт орж хяналт, мониторинг хийх үзүүлэлт өөрчлөгдөх тохиолдолд өөрчлөлтийг түргэн шуурхай хийх чадвартай байна.
- Урьдчилгаа төлбөр авалгүйгээр “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжтай байна.
- Датабааз, файлын сан, програм хангамж, мэдээллийг цахим халдлагаас хамгаалах мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системийн шийдэлтэй байна.

Гүйцэтгэгч нь дараах хүснэгтэд тусгасан шаардлагатай мэдлэг чадварт, туршлагатай боловсон хүчнээс бүрдсэн баг санал болгох ба гэрээнд заасан ажил үүргийг заасан хугацаанд гүйцэтгэх чадвартай байна. Мөн дараах мэдлэг чадварыг зохих түвшинд хангаж, санал болгож буй ажлын төлөвлөгөө ба арга зүйд тулгуурлан хамгийн сайн баг бүрдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Албан тушаал	Чиг үүрэг	Ажлын туршлага
Багийн ахлагч	Ажлыг удирдан зохион байгуулах, гэрээлэгчийг төлөөлж захиалагчтай харилцах	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажил, төсөл, багийн ажиллагаанд оролцож ажиллаж байсан туршлагатай байх</li> <li>• Судалгаа, шинжилгээ, статистик буюу холбогдох чиглэлээр зэрэг цолтой бол давуу тал болно</li> </ul>
Хяналтын ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээний бүтэц, загварыг боловсруулах, хяналт,	<ul style="list-style-type: none"> <li>• Статистик, судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай</li> <li>• Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай</li> <li>• Мэдээ, тайланг алдаагүй, нягт нямбай гаргах чадвартай</li> </ul>

	мониторингийн явцад хяналт тавих	
Програм хангамж хариуцсан ажилтан	Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх	<ul style="list-style-type: none"> <li>Програм хангамжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх</li> <li>Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх</li> <li>Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх чадвартай байх</li> </ul>
Техник, ашиглалт хариуцсан ажилтан	Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлээрээ л ажилласан туршлагатай байх</li> <li>Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх</li> <li>Техник төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хийх, техникийн өргөтгөл хийх чадвартай байх</li> <li>Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх</li> </ul>
Статистик судалгааны ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээнд анализ, шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>Статистик, судалгаа шинжилгээний чиглэлээр боловсрол эзэмшсэн</li> <li>Дээд боловсролтой</li> <li>Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай байх</li> </ul>
Мониторингийн ажилтан	Бүртгэл хийх, тайлан бэлдэх	<ul style="list-style-type: none"> <li>Их хэмжээний мэдээллийн баазтай ажиллах чадвартай</li> </ul>

## 8. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ БА АЖЛЫН ХУВААРЬ

Гүйцэтгэгч нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах арга зүй, үйл ажиллагааны хуваарийг боловсруулна. Энэхүү үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө болон үүнтэй ижил төстэй даалгаврыг ямар хугацаа, техникийн туслалцаа, ажлын бүтэц бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байсан туршлагын баримтжуулалтыг хавсаргавал зохино.

## 9. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ УДИРДАМЖ

9.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн шаардсан тухай бүр, тайлангийн бүтэц, аргачлалын дагуу тайланг нэгтгэж, дүгнэлт гаргахад ойлгомжтой, ирүүлсэн тайлан, мэдээг шууд ашиглах боломжтой, дахин боловсруулалт хийх шаардлагагүй, хялбар байдлаар ирүүлнэ. Ирүүлсэн тайлан мэдээнд алдаа

гарсан нь тогтоогдсон, тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлээгүй, урт хугацаагаар /14 хоногоос дээш/ хоцроосон тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дуусгавар болгох үндэслэл болно.

- 9.1. Захиалагчийн шаардсаны дагуу радиогийн хөтөлбөрийн бичлэгийг хөрвүүлэх хугацаа нь тухайн бичлэгийн формат, чанар, бичлэг хүлээн авах шийдэл зэргээс хамаарч хугацаанд өөрчлөлт орж болохыг үгүйсгэхгүй. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.
- 9.2. Сонгуулийн сурталчилгааны тайланг 7 хоногоор болон сонгуулийн нийт хугацааны тайланг тайлан тус бүрээр нэгтгэн ирүүлнэ.
- 9.3. Нийт тайланг CD–д бичиж баталгаажуулан захиалагчид нэхэмжлэхийн хамт ирүүлнэ.

## 10. МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ /ЗАГВАР/

- 10.1. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн протокол; Протокол нь радиогийн нэр, огноо, сурталчилгааны нэвтрүүлгийн нэр, эхэлсэн цаг, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа (цаг:мин:сек-ээр болон сек-ээр), эх сурвалж, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, зэрэг мэдээллийг агуулсан байх.
- 10.2. Радиогоор нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 60 минутаас илүүгүй заалтыг эсэх тайлан - огноо, радиогийн нэр (сурталчилгаа дамжуулах эрхтэй эсэх), дэх сурвалжаа тодорхой дурдсан эсэх, “төлбөртэй” эсвэл “захиалгатай” нэвтрүүлэг болон рекламны хугацаа, эх сурвалжаа дурдаагүй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, зөрчилтэй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, нийт хугацаа, 60 минутаас хэтэрсэн хугацаа зэрэг мэдээллийг агуулсан байх.
- 10.3. Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвслээс нэр дэвшигчдэд ногдож байгаа эсэх, шаардлага хангасан эсэх тайлан - огноо, радиогийн нэр (сурталчилгаа дамжуулах эрхтэй эсэх), дэх сурвалжаа тодорхой дурдсан эсэх, “төлбөртэй” эсвэл “захиалгатай” нэвтрүүлэг болон рекламны хугацаа, эх сурвалжаа дурдаагүй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, зөрчилтэй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, нийт хугацаа, 15 минутаас хэтэрсэн хугацаа зэргийн агуулсан байх.
- 10.4. Радиогийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 (таван) минутаас хэтрүүлсэн эсэх тайлан - огноо, радиогийн нэр, мэдээллийн хөтөлбөрийн нэр, эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, секундээр, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн мэдээний эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацааг зэрэг мэдээллийг агуулсан байх.
- 10.5. Олон нийтийн радиогоор дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийн биелэлтэд мониторинг хийх, хэрэгжилтийн тайлан - огноо, нэвтрүүлгийн нэр, эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн хэлбэр, цагийн хуваариар гарсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.
- 10.6. Орон нутгийн радиогийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайланг захиалагчийн шаардсан үзүүлэлтийн дагуу тухай бүр хүргүүлнэ.

Хавсралт-1

РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЖАГСААЛТ /нийт /

№	ДАВТА МЖ, МГЦ	ЭЗЭМШИГЧ	РАДИОГИЙН НЭР	ХАМРАХ ХҮРЭЭ
1	88.3	Эм Жи Эл Радио ньус ХХК	Эм Жи Эл Радио Ньюс	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Булган, Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Завхан, Говь- Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймаг
2	88.8	СКОД ХХК	Medee.mn	Улаанбаатар хот
3	89.3	Сета тех ХХК	Аялгуу	Улаанбаатар хот
4	89.7	Жавзандамба хутагт төв ТББ	Зохист аялгуу	Улаанбаатар хот
5	90.5	Улаанбаатар телевиз ХХК	VIP радио	Улаанбаатар хот
6	91.1	Монгол комикс ХХК	Цаг үе залуус	Улаанбаатар хот
7	91.7	Хэмнэлт долгион медиа групп ХХК	Метро лоунж	Улаанбаатар хот
8	92.1	Смарт коммуникэйшн ХХК	Тойм	Улаанбаатар хот
9	92.5	Тэргүүн медиа ХХК	Стар	Улаанбаатар хот
10	95.1	Шүхэр ТББ	Хамаг Монгол	Улаанбаатар хот
11	95.7	Хүүхэд, ирээдүй, соёл боловсрол сан ТББ	Арга билиг	Улаанбаатар хот
12	96.3	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	Авто радио	Улаанбаатар хот
13	96.9	Эх элгэн нутаг ХХК	Элгэн нутаг	Улаанбаатар хот
14	97.5	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд шашинтны төв	Лавайн эгшиг	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь,

				Даланзадгад, Дундговь, Орхон, Өвөрхангай, Булган, Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймаг
15	98.1	Радиоком Монгол ХХК	Формула	Улаанбаатар хот
16	98.5	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	Best	Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Ховд, Увс аймаг
17	98.9	Монголиан Мюзик Медиа ХХК	Бизнес радио	Улаанбаатар хот
18	99.3	Ньюмедиа ХХК	Инээмсэглэл	Улаанбаатар хот
19	99.7	Дижитал радио ХХК	Их Монгол	Улаанбаатар хот
20	100.1	РФ ХХК	kiss radio	Улаанбаатар хот
21	100.5	НС Холбоо ХХК	Гийнгоо	Улаанбаатар хот
22	101.7	Агрегатор ХХК	Тэргүүлэгч	Улаанбаатар хот
23	102.1	Эм Эс Жи Эм Эл ХХК	Монголчуудын радио	Улаанбаатар хот
24	102.5	Бадруун ХХК	Радио УБ	Улаанбаатар хот
25	103.6	Медиахолдинг ХХК	Тэнгэрлэг радио	Улаанбаатар хот
26	104	Ви Өү Эм ХХК	Эрүүл амьдралын радио	Улаанбаатар хот
27	104.5	Салхи Энтертэйнмэнт ХХК	Гэр бүлийн радио	Улаанбаатар хот, Улаанбаатар.Багануур дүүрэг, Улаанбаатар.Налайх дүүрэг, Дорнод.Хэрлэн сум, Сүхбаатар.Баруун-Урт сум, Хэнтий.Хэрлэн сум, Төв.Зуунмод сум, Говьсүмбэр.СҮМБЭР, Сэлэнгэ.Сүхбаатар сум, Дорноговь.Сайншанд сум, Дархан-Уул.Шарын гол сум, Дархан-Уул.Хонгор сум, Дархан-

				Уул.Орхон сум, Дархан-Уул.Дархан сум, Өмнөговь.Даланзадгад сум, Дундговь.Сайнцагаан сум, Орхон.Жаргалант сум, Орхон.Баян-Өндөр сум, Өвөрхангай.Арвайхээр сум, Булган.Булган сум, Баянхонгор.Баянхонгор сум, Архангай.Эрдэнэбулган сум, Хөвсгөл.Мөрөн сум, Завхан.Улиастай сум, Говь-Алтай.Есөнбулаг сум, Баян-Өлгий.Өлгий сум, Ховд.Жаргалант сум, Увс.Улаангом сум
28	104.7	Буян налайх ХХК	Буян	Налайх дүүрэг
29	105.5	Чугу ХХК	VIBE	Монгол Улс
30	106.6	Стандарт Ви Оү Эй ХХК	Америкийн дуу хоолой	Улаанбаатар хот
31	107	И Зэт Эф Эм ХХК	Эх дэлхий радио	Улаанбаатар хот
32	107.5	Билэг санаа ХХК	Шинэ долгион	Улаанбаатар хот
33	100.9	МҮОНРТ	РЗ залуусын радио /МҮОНР-III суваг/	Улаанбаатар хот
34	103.1	МҮОНРТ	Монголын радио /МҮОНР-II суваг/	Монгол Улс
35	106	МҮОНРТ	Монголын радио /МҮОНР 1-р суваг/	Монгол Улс
36	89.1	Түвдэнгийн Бор Интернешнл ХХК	Миний говь	Өмнөговь
37	102.6	Ноён уул радио НҮТББ	Ноён уул радио	Өвөрхангай
38	107.1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Эрдэнэт долгион	Орхон
39	106.5	Хос дог ХХК	Бизнес радио	Дархан-Уул
40	106.5	Мөнхийн үйлс саруул ХХК	Эрдэнэтийн дуу хоолой	Орхон
41	89.1	Ц.Даваацогт	Сорм	Хөвсгөл



42	89.1	Сайн цагийн залуус НҮТББ	Сайн цагийн залуус	Өвөрхангай
43	87.9	МОНБЗ Продакшн ХХК	Монгол тандаа зүтгэе залуусын радио	Дархан-Уул
44	107	Рашаантын баясгалант ХХК	Эх нутаг	Завхан
45	89.1	Ди медиа агентлаг ХХК	Бизнесийн хөтөч	Дорноговь
46	101.1	Баян зам тээвэрчдийн холбоо ТББ	Баянзам	Өмнөговь
47	89.1	Топ дэвшил ХХК	Эгшиг радио	Орхон
48	89.1	Саяар дорно ХХК	iMongolia radio	Дорнод
49	89.1	Инээмсэглэл дүүрэн ирээдүй НҮТББ	Тэмүүлэл	Ховд
50	88.7	Дархан мэдээлэл төв ХХК	FM 88.7	Дархан-Уул
51	89.5	Төрөлх алтай ТББ	FM 89.5	Говь-Алтай
52	89.5	Одтой цэг ХХК	Найс радио	Дархан-Уул
53	89.1	Хасүби медиа ХХК	89.1	Хөвсгөл
54	89.1	Ар Би Эм Ти ХХК	FM 89.1	Архангай
55	89.5	Одтой цэг ХХК	Nice radio	Сэлэнгэ
56	ФМ 89.1	Дадишуар гоёл ХХК	ФМ 89.1	Дорноговь
57	89.1	Саксесс цэц мастер ХХК	89.1	Хэнтий
58	87.9	Тал нутгийн аялгуу ФМ ХХК	87.9	Сүхбаатар
59	89.1	Хөндлөн хөгжил ХХК	89.1	Төв
60	89.1	Хөндлөн хөгжил ХХК	89.1	Увс
61	104.5	Багануур хөгжлийн зам НҮТББ	Багануур гэр бүлийн радио FM-104.5	Улаанбаатар

